



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар A/60

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын  
үйлчилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь.

1. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэн Санжаагийн Эрдэнэчимэг (РН40092566), Тосонцэнгэл сумын иргэн Доржийн Долгорсүрэн (РК40040504), Бүрэнтогтох сумын иргэн Ёндонгийн Нацагдорж (УГ33070111), Их-Уул сумын иргэн Лувсанмоломын Түмэнбаяр (РЖК56082911) нар нь ах дүү, харж хандах боломжгүй, өөрийн гэсэн орон гэргүй, байнгын асаргаанд байх шаардлагатай, ганц бие ахмад настнууд тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Т.Октябрьбаяр)-д даалгасугай.

2. Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг дээрх сумын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010189

Захирамж 2024